



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/379

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Нямжав овогтой Сарантуяа (ХЛ66032403)-ын Мөрөн сум 13 дугаар багт байршилтай 9647м² нийтийн орон сууцны зориулалтаар эзэмшүүлсэн газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан тул өөрийнх нь хүсэлтийн дагуу 40 жилийн хугацаагаар сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/574 дүгээр захирамжийн хавсралтын 2 дахь заалтыг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч иргэн Нямжавын Сарантуяа (ХЛ66032403)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН